

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/22/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чингис хот
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.7.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	14
3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1. Залруулсан алдаа	15
4.2. Төлбөрийн акт	15
4.3. Албан шаардлага	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
6. Аудитын тайлангийн хавсралт	16
6.1. Төлбөрийн акт 2022.02.25 №04 /A2370452/ ХЭА-2022/22/НА-СТА-ТШЗ	16
6.2. Төлбөрийн акт 2022.02.25 №05 /A2370452/ ХЭА-2022/22/НА-СТА-ТШЗ	17
6.3. Албан шаардлага 2022.02.25 №32 /A2370452/ ХЭА-2022/22/НА-СТА-ТШЗ	18
6.4. Албан шаардлага 2022.02.25 №33 /A2370452/ ХЭА-2022/22/НА-СТА-ТШЗ	19
6.5. Албан шаардлага 2022.02.25 №34 /A2370452/ ХЭА-2022/22/НА-СТА-ТШЗ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ПТК	Политехникийн коллеж



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.02.25 № 62
танай _____ -ны № _____ -т

**ХЭНТИЙ АЙМГИЙН
ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Г.НЯМХАТАН ТАНАА**

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа:2021.12.31

Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	477,390,630.85	493,575,979.85
33	АВЛАГА	34,461,822.00	32,495,288.51
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	32,401.00	23171141,505,067.51
33200	Төлбөргүй үйлчилгээний авлага	6,009,501.00	6,009,501.00
335	Бусад авлага	28,419,920.00	24,980,720.00
3351	Байгууллагаас авах авлага	13,339,200.00	9,900,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	15,080,720.00	15,080,720.00
35	БАРАА МАТЕРИАЛ	442,928,808.85	461,080,691.34
351	Түүхий эд материал	521,530.00	518,538.00
35130	Эм боох материал	521,530.00	518,538.00
354	Хангамжийн материал	354,833,278.85	369,548,153.34
35410	Бичиг хэргийн материал	6,737,850.00	8,480,950.00
35420	Аж ахуйн материал	118,189,219.75	130,442,699.94
35430	Сэлбэг хэрэгсэл	8,583,400.00	8,247,400.00
35450	Барилгын засварын материал	163,304,619.10	156,540,563.40
35460	Хүнсний материал	2,008,615.00	2,578,865.00
35470	Бусад хангамжийн материал	56,009,575.00	63,257,675.00
35600	Мал амьтад	87,574,000.00	91,014,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,088,448,992.58	6,238,875,496.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,088,448,992.58	6,238,875,496.69
392	Биет хөрөнгө	4,616,068,992.58	4,766,495,496.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,408,674,347.00	4,786,168,214.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(303,150,291.68)	(448,349,986.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	422,376,102.23	422,376,102.23
39204	Хуримтлагдсан элэгдэл	(251,038,225.95)	(289,543,580.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	939,078,957.92	917,105,222.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	(679,951,337.95)	(694,119,570.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	174,693,541.50	167,291,154.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(136,604,666.97)	(139,876,745.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,696,799.00	13,674,242.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,183,490.63)	(11,540,933.67)
39217	Ном	39,477,258.11	43,311,378.11
393	Биет бус хөрөнгө	1,472,380,000.00	1,472,380,000.00
39301	Програм хангамж	16,630,000.00	16,630,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(16,630,000.00)	(16,630,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,472,380,000.00	1,472,380,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,565,839,623.43	6,732,451,476.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	58,622.05	1,148,031.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	58,622.05	1,148,031.00
413	Өглөг	58,622.05	1,148,031.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	58,622.05	1,148,031.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,565,781,001.38	6,731,303,445.54
51	Засгийн газрын хувь оролцоо	6,565,781,001.38	6,731,303,445.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,778,950,677.93	1,778,950,677.93
512	Хуримтлагдсан үр дүн	4,686,837,272.68	4,858,097,979.51
51210	Өмнөх үеийн үр дүн	4,686,837,272.68	4,692,575,535.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	165,522,444.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99,993,050.77	94,254,788.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,565,839,623.43	6,732,451,476.54

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайланг хугацаа 2021.12.31

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Төгрөгөөр/ Тайланг оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,374,529,902.00	2,333,946,803.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	489,295,802.00	483,649,503.84
120	Нийтлэг татварын бус орлого	489,295,802.00	483,649,503.84
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	489,295,802.00	483,649,503.84
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,852,602.00	8,719,279.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	4,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	479,443,200.00	470,930,224.84
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,885,234,100.00	1,850,297,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,872,688,100.00	1,798,601,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,872,688,100.00	1,798,601,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,546,000.00	51,695,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчиг бус этгээдээс авсан хандив, тусламж	2,090,000.00	32,979,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,870,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон	10,456,000.00	15,846,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,268,431,048.87	2,168,424,359.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,268,431,048.87	2,168,424,359.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,936,529,011.41	1,991,303,161.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	940,892,808.29	1,004,930,053.38
210101	Үндсэн цалин	640,212,404.26	653,063,744.78
210102	Нэмэгдэл	203,959,827.40	233,558,099.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,979,929.00	50,935,500.00
210104	Урамшуулал	58,740,647.63	60,310,539.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	7,062,170.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,155,289.30	130,592,449.69
210201	Тэтгэврийн даатгал	81,012,013.00	91,358,358.80
210202	Тэтгэмжийн даатгал	9,517,933.50	10,164,544.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,559,441.43	8,031,340.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,824,165.16	1,912,565.53
210205	Эрүүл мэндийн даатгал	18,241,736.21	19,125,640.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	374,536,212.00	408,061,094.00
210301	Гэрэл, цахилгаан	30,965,210.00	31,865,220.00
210302	Түлш, халаалт	338,357,395.00	371,258,102.00
210303	Цэвэр, бохир ус	5,213,607.00	4,937,772.00
2104	Хангамж, бараа материалын зардал	157,864,504.60	102,423,304.31
210401	Бичиг хэрэг	1,329,900.00	2,609,000.00
210402	Гээвэр, патахуун	2,485,110.00	2,950,799.50
210403	Шуудан, холбоо, ингэрнтийн төлбөр	3,522,840.00	2,286,569.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,873,800.00	3,994,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,388,960.00	11,193,114.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	128,604,000.00	58,720,000.00
210408	Бараа материал аргалсны зардал	10,659,894.60	20,669,221.81
2105	Нормативт зардал	28,926,274.00	19,519,653.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	953,990.00	85,400.00
210502	Хоод, хүнс	27,509,924.00	18,118,553.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	462,360.00	1,315,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,522,710.00	9,453,330.00
210604	Урсгал засвар	10,522,710.00	9,453,330.00
2107	Томилголт, зочны зардал	690,000.00	551,000.00
210702	Дотоод албан томилолт	690,000.00	551,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,129,759.00	7,325,436.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,162,000.00	1,640,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,400,000.00	2,720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн гатвар	632,500.00	231,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	320,000.00	266,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	330,000.00	200,000.00
210807	Газрын төлбөр	285,259.00	268,136.00

**Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	297,811,454.22	308,446,840.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,150,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,147,920.00	58,176,279.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	260,663,534.22	245,120,061.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	331,902,037.46	177,121,198.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	142,905,700.00	142,103,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	67,596,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшигтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	138,355,000.00	61,320,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,550,700.00	13,186,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	188,996,337.46	35,017,798.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	188,996,337.46	35,017,798.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	106,098,853.13	165,522,444.16
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	106,098,853.13	165,522,444.16

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,778,950,677.93	109,492,531.77	4,571,238,938.55		6,459,682,148.25
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	9,499,481.00		9,499,481.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,778,950,677.93	109,492,531.77	4,580,738,419.55	-	6,469,181,629.25
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(9,499,481.00)	-		(9,499,481.00)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	106,098,853.13		106,098,853.13
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,778,950,677.93	99,993,050.77	4,686,837,272.68	-	6,565,781,001.38
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,778,950,677.93	99,993,050.77	4,686,837,272.68	-	6,565,781,001.38
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,738,262.67		5,738,262.67
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,778,950,677.93	99,993,050.77	4,692,575,535.35	-	6,571,519,264.05
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(5,738,262.67)	-		(5,738,262.67)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	165,522,444.16		165,522,444.16
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,778,950,677.93	94,254,788.10	4,858,097,979.51	-	6,731,303,445.54

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайланг хугацаа: 2021.12.31

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайланг оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,895,086,452.00	1,863,016,579.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,852,352.00	12,719,279.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,852,352.00	12,719,279.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,852,352.00	12,719,279.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,852,352.00	8,719,279.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	4,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,885,234,100.00	1,850,297,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,872,688,100.00	1,798,601,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,872,688,100.00	1,798,601,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,546,000.00	51,695,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,090,000.00	32,979,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,870,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,456,000.00	15,846,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,895,086,452.00	1,860,144,959.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,895,086,452.00	1,860,144,959.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,563,184,414.54	1,683,023,760.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	940,926,074.24	1,005,268,110.94
210101	Үндсэн цалин	641,100,308.20	662,478,031.74
210102	Нэмэгдэл	203,136,650.41	227,647,677.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,948,468.00	48,938,298.60
210104	Урамшуулал	58,740,647.63	58,931,615.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	7,272,488.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,095,802.30	130,637,649.69
210201	Тэтгэврийн даатгал	80,952,526.00	91,403,558.80
210202	Тэтгэмжийн даатгал	9,517,933.50	10,164,544.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,559,441.43	8,031,340.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,824,165.16	1,912,565.53
210205	Эрүүл мэндийн даатгал	18,241,736.21	19,125,640.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	374,536,212.00	408,105,094.00
210301	Гэрэл, цахилгаан	30,965,210.00	31,865,220.00
210302	Түлц, халаалт	338,357,395.00	371,258,102.00
210303	Цэвэр, бохир ус	5,213,607.00	4,981,772.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,888,303.00	29,546,098.00
210401	Бичиг хэрэг	2,007,100.00	3,783,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,486,200.00	2,940,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,522,840.00	2,286,569.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,842,700.00	3,375,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,029,463.00	17,160,229.00
2105	Нормативт зардал	28,478,174.00	21,748,911.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	185,000.00	163,000.00
210502	Хоол, хүнс	24,990,574.00	18,679,311.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,302,600.00	2,906,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,393,460.00	10,813,380.00
210601	Багаж, техник хэрэгсэл	4,580,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	10,813,460.00	7,813,380.00
2107	Томилолт, зочны зардал	690,000.00	551,000.00
210702	Догоод албан томилолт	690,000.00	551,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,027,759.00	9,253,436.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,072,000.00	1,640,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	990,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,400,000.00	2,720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	632,500.00	447,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	320,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,328,000.00	2,128,000.00
210807	Газрын төлбөр	285,259.00	268,136.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,148,630.00	67,100,081.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,601,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,148,630.00	61,498,581.00

Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	331,902,037.46	177,121,198.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	142,905,700.00	142,103,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,070,300.00	67,596,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	107,284,700.00	61,320,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,550,700.00	13,186,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	188,996,337.46	35,017,798.37
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	188,996,337.46	35,017,798.37
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	2,871,620.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,871,620.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,871,620.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,871,620.00
223001	Бусад хөрөнгө	-	2,871,620.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(2,871,620.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,818,601,800.00	1,776,303,280.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,818,601,800.00	1,776,303,280.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,687,228,400.00	1,644,929,880.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	997,228,200.00	997,154,349.94
210101	Үндсэн цалин	629,783,500.00	662,478,031.74
210102	Нэмэгдэл	244,626,300.00	227,227,041.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	63,525,000.00	48,938,298.60
210104	Урамшуулал	59,293,400.00	58,510,978.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,795,900.00	129,645,863.69
210201	Тэтгэврийн даатгал	94,226,700.00	90,719,497.80
210202	Тэтгэмжийн даатгал	10,142,300.00	10,087,613.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,113,800.00	7,969,795.05
210204	Ажилгүйдлийн даатгал	2,028,500.00	1,897,179.53
210205	Эрүүл мэндийн даатгал	20,284,600.00	18,971,777.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	424,109,900.00	408,105,094.00
210301	Гэрэл, цахилгаан	31,371,600.00	31,865,220.00
210302	Түлш, халаалт	383,074,900.00	371,258,102.00
210303	Цэвэр, бохир ус	9,663,400.00	4,981,772.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,946,300.00	15,945,569.00
210401	Бичиг хэрэг	1,684,600.00	1,684,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,739,900.00	1,739,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,292,300.00	2,286,569.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,370,600.00	3,375,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,858,900.00	6,858,900.00
2105	Нормативт зардал	40,709,600.00	20,100,568.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	163,000.00	163,000.00
210502	Хоол, хүнс	37,640,000.00	17,030,968.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,906,600.00	2,906,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,000,000.00	9,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	6,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	552,000.00	551,000.00
210702	Дотоод албан томилолт	552,000.00	551,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,712,500.00	9,253,436.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,640,000.00	1,640,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,720,000.00	2,720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	480,500.00	447,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	216,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,128,000.00	2,128,000.00
210807	Газрын төлбөр	528,000.00	268,136.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,174,000.00	55,174,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	55,174,000.00	55,174,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,373,400.00	131,373,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,373,400.00	131,373,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,596,400.00	67,596,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	61,320,400.00	61,320,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,456,600.00	2,456,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,818,601,800.00	1,776,303,280.63
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,798,601,800.00	1,763,584,001.63
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,798,601,800.00	1,763,584,001.63
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	12,719,279.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,000,000.00	8,719,279.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	4,000,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021.12.31

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	51,695,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	51,695,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	231,40,965,500.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	8,113,761.00
210102	Нэмэгдэл	-	420,636.00
210104	Урамшуулал	-	420,637.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	7,272,488.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	991,786.00
210201	Тэтгэврийн даатгал	-	684,061.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	76,931.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	61,545.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	15,386.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	153,863.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	14,602,149.00
210401	Бичиг хэрэг	-	2,098,800.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,200,400.00
210404	Ном, хэвлэл	-	1,001,620.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	10,301,329.00
2105	Нормативт зардал	-	1,648,343.00
210502	Хоол, хүнс	-	1,648,343.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,683,380.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,870,000.00
210604	Урсгал засвар	-	1,813,380.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	11,926,081.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,601,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,324,581.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	10,730,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	10,730,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	10,730,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	51,695,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	51,695,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	32,979,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,870,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	15,846,300.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Хуланхатан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймгийн Политехникийн коллежийн эрхэм зорилго нь “Чанартай сургалт-тогтвортой хөдөлмөр эрхлэлт” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймгийн Политехникийн коллежийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газраас Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,268.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 22.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 100.0 сая төгрөгөөр өмнөх оноос буурсан тул гүйцэтгэлийн материаллаг байдлыг 16.3 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 166.6 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	34.5	32.5	(2.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	442.9	461.1	18.2
Үндсэн хөрөнгө	6,088.4	6,238.9	150.4
Нийт хөрөнгө	6,565.8	6,732.5	166.6
Өр төлбөр	0.1	1.1	1.1
Засгийн газрын оролцоо	6,565.8	6,731.3	165.5
Засгийн газрын оролцоо/Өмч - Төрийн/	1,779.0	1,779.0	-
Өмнөх үеийн үр дүн	4,686.8	4,692.6	5.7
Тайлант үеийн үр дүн	-	165.5	165.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	100.0	94.3	(5.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,565.8	6,566.9	1.1

Авлага дансны үлдэгдэлд ажилчидтай холбоотой 1.5 сая, төлбөртэй үйлчилгээний 6.0 сая, байгууллагаас авах 9.9 сая, хувь хүнээс авах 15.1 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 461.1 сая болж 18.2 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бусад хангамжийн материал, мал амьтад дансны үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,238.9 сая төгрөг болж 150.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үндсэн хөрөнгө акталж данснаас хассан 44.6 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдаж, урсгал төсвийн худалдан авалтаар 2.8 сая, Азийн хөгжлийн банкнаас өгсөн хандивын 392.7 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд татварын байгууллагад төлөх 1.1 сая төгрөгийн өр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,731.3 сая болж 165.5 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр өссөн байна.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү данс акталж данснаас хасагдсан хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 5.7 сая төгрөгөөр буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 40.6 сая төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 101.0 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг буурсантай холбоотой байна

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 2,317.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 798.7 сая төгрөгөөр бууруулж 1,818.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,818.6 сая төгрөгийн төсөв баталсныг 1,798.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 16.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 4.0 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,798.6 сая, үндсэн ажиллагааны орлого 8.7 сая, туслах үйл ажиллагааны орлого 4.0 сая төгрөг нийт 1,811.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,776.3 сая төгрөгийг зарцуулж 35.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 33.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас 2.9 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 15.8 сая нийт 51.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансанд мэдээлбэл зохих 2,875.6 сая төгрөгийн 59 гүйлгээ мэдээлэхээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын 199.4 сая төгрөгийн 8, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 88.5 сая төгрөгийн 4 гүйлгээг хугацаа хоцроож, цалингаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 193.8 сая төгрөгийн 5, зарлагын 78.4 сая төгрөгийн 5 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.7.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсөв захирагчдад Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасан.

Аймгийн Политехникийн коллеж нь батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 3.3 сая төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоогдсон 0.9 сая төгрөгийн 1 төлбөрийн актыг төлж барагдуулан, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 586.2 сая төгрөгийн 1 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 573.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.6 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 569.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн.

4.1. Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

4.2. Төлбөрийн акт

Аудитаар залруулагдаагүй 3.6 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлогоос төсөвт төвлөрүүлэх 1,595.2 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

2. Сурагчдад олгогдоогүй тэтгэлгийн 1,989.2 мянган төгрөгийг нэмэлт дансанд орлого авч зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3. Албан шаардлага

Аудитаар 6.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Хувь хүмүүсээс авах төлбөртэй үйлчилгээний 6.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн ПТК	3	9.6			2	3.6	1	6.0		
Дүн		3	9.6			2	3.6	1	6.0		
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Хэнтий аймгийн ПТК	2	563.5					2	563.5		
Дүн		2	563.5					2	563.5		
Нийт дүн		5	573.1			2	3.6	3	569.5		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 04/А 2370452
ХТ-А-2022/22/НН-ГА-ТШЗ

Чингис хот

Г Төлбөр барагдуулах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлсний орлогоос 1,595.2 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын 2-д "Түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх хэмжээг нийт орлогын дүнгийн 40 хувиар тогтоосугай" гэсэн заалтыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.2 -д "Төрийн болон орон нутгийн эд хөрөнгийг түрээслүүлсэн, ашиглуулсны төлбөр болон борлуулсны орлогыг дутуу төвлөрүүлсэн, эсхүл төвлөрүүлээгүй" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсөвт төвлөрүүлээгүй 1,595.2 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Политехникийн коллежийн захирал Г.Нямхатан, нягтлан бодогч Д.Наранцацрал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

Аудитор

Аудитын менежер



Б.Хуланхатан

Д.Оюунтуяа

023050011



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны Саврын 25 өдөр

Дугаар 05/А/2370/452
ХТ-А-2022/22/НТ-СТА-ТЦС

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сурагчдад олгогдоогүй тэтгэлгийн 1,989.2 мянган төгрөгийг нэмэлт дансанд авч зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д "Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно", 47.1.1 "төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж"; 47.1.2 "төсвийн жилийн явцад Улсын Их Хурлаас соёрхон баталсан, Засгийн газар хоорондын гэрээ болон олон улсын байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл"; 47.1.3 "Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө"; 47.1.4 "дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө"; 47.1.5 "төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого"; 47.1.7 "Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 -д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

- Сурагчдад олгогдоогүй 1,989.2 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
- Актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Политехникийн коллежийн захирал Г.Нямхатан, нягтлан бодогч Д.Наранцацрал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

Аудитор

Аудитын менежер

Б.Хуланхатан

Д.Оюунтуяа

2317144297
СЮА0048.0074082

023050015



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 05

Дугаар 32/А 2370452
ХТ-2022/22/НТ-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны сайтад мэдээлбэл зохих 288.0 сая төгрөгийн 12 гүйлгээг хугацаа хоцроосон, 272.2 сая төгрөгийн 10 гүйлгээг мэдээлээгүй, мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв мэдээлж байх гэсэн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Политехникийн коллежийн захирал Г.Нямхатан, нягтлан бодогч Д.Наранцацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Б.Хуланхатан

Аудитын менежер

Д.Оюунтуяа



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 33 / А2370452
ХТА-2022/22/НА-СТА-ТЦЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 3.3 сая төгрөгийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Политехникийн коллежийн захирал Г.Нямхатан, нягтлан бодогч Д.Наранцацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Б.Хуланхатан

Аудитын менежер

Д.Оюунтуяа



02304605



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 34/АД 370452
ХЭА-2022/22/НА-СТА-ТШЗ

Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хувь хүмүүсээс авах төлбөртэй үйлчилгээний 6.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7 -д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлбөртэй үйлчилгээний авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Политехникийн коллежийн захирал Г.Нямхатан, нягтлан бодогч Д.Наранцацрал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Аудитор

Аудитын менежер



Б.Хуланхатан

Д.Оюунтуяа